

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

20... оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

ГАЗРЫН ТӨЛБӨРИЙН ТУХАЙ /шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь газрын хязгаарлагдмал эрхтэй этгээд, газар ашиглагчид газрын төлбөр ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөх, төсөвт төвлөрүүлэх, төлөвлөх, тайлагнах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Газрын төлбөрийн тухай хууль тогтоомж

2.1.Газрын төлбөрийн тухай хууль тогтоомж нь Газрын ерөнхий хууль, Кадастрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төсвийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан бусад хуулиас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Газрын төлбөр төлөгч

3.1.Хууль тогтоомжийн дагуу газрын хязгаарлагдмал эрх олгохоор шийдвэрлэсний үндсэн дээр газрыг ашиглаж байгаа Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаад улсын хуулийн этгээд, гадаадын иргэн, харьяалалгүй хүн газрын төлбөр төлөгч байна.

3.2.Газрын төлбөр төлөгч нь төрийн өмчийн газрыг ашигласны төлөө газрын төлбөрийг улс, орон нутгийн төсөвт төлнө.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ТӨЛБӨР ТООЦОХ ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛБӨРИЙН ХУВЬ, ХЭМЖЭЭ

4 дүгээр зүйл.Газрын төлбөр тооцох үзүүлэлт

4.1.Газрын төлбөрийг дараах үзүүлэлтийг харгалзан тооцно:

4.1.1.бэлчээрийн газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгой тутамд;

4.1.2.зам, шугам сүлжээний газрын төлбөрийг метр тутамд;

4.1.3.ашигт малтмалын болон ашигт малтмал, байгалийн хий ашиглах үйл ажиллагааны зориулалттай газрын төлбөрийг тусгай зөвшөөрлийн нийт талбайгаар;

4.1.4.энэ хэсгийн 4.1.1, 4.1.2, 4.1.3-т зааснаас бусад газрын төлбөрийг энэ хуулийн 6.2-т заасан нийт талбайд.

4.2.Бэлчээрийн газраас авах газрын төлбөрийг хонин толгойд шилжүүлсэн малын толгойн тоонд ногдуулахдаа өмнөх жилийн эцэст тоологдсон адууг 6.0, үхрийг 4.0, тэмээг 2.0, ямааг 3.0 гэсэн итгэлцүүрээр тус тус тооцно.

4.3.Газрын тос хайх, олборлох үйл ажиллагаа явуулж байгаа газрын төлбөрийг тогтоохдоо Засгийн газрын бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцлийг баримтална.

5 дугаар зүйл. Газрын төлбөрийн хувь, хэмжээ

5.1.Газрын төлбөрийг Кадастрын тухай хуульд заасны дагуу тогтоосон газрын суурь үнэлгээнээс дараах хувь хэмжээгээр тооцно.

5.1.1.бэлчээрийн газрын төлбөрийг нэг хонин толгой тутамд 0.05 хувиар;

5.1.2.хадлангийн газрын төлбөрийг нэг га тутамд 0.3 хувиар;

5.1.3.үр тариа болон бусад ургамлын тариалангийн талбайн газрын төлбөрийг нэг га тутамд 0.05 хувиар;

5.1.4.төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний тариалангийн талбайн газрын төлбөрийг нэг га тутамд 0.3 хувиар;

5.1.5.хот, тосгон, бусад суурины газрын төлбөрийг нэг га тутамд 1.0 хувиар;

5.1.6.хөдөө аж ахуйн барилга байгууламжийн дэвсгэр газрын төлбөрийг тухайн хот, тосгон, бусад суурины үнэлгээний бүсчлэлийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнэлгээнээс нэг га тутамд 1.0 хувиар;

5.1.7.ашигт малтмал, байгалийн хий ашиглах зориулалттай талбайн газрын төлбөрийг дараах байдлаар тогтооно.

5.1.7.1.үйлдвэрлэлийн барилга байгууламжийн хувьд хот, тосгон, бусад суурины үнэлгээний бүсчлэлийн хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнэлгээнээс нэг га тутамд 1.0 хувиар;

5.1.7.2.уурхайн ашиглалт явуулж буй талбайн хувьд хот, тосгон, бусад суурины үнэлгээний бүсчлэлийн хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнэлгээнээс нэг га тутамд 2.0 хувиар;

5.1.7.3. энэ хуулийн 5.1.7.1, 5.1.7.2-оос бусад уурхайн талбайн хувьд хот, тосгон, бусад суурины үнэлгээний бүсчлэлийн хөдөө аж ахуйгаас бусад үйлдвэрлэлийн зориулалттай газрын суурь үнэлгээнээс нэг га тутамд 0.1 хувиар;

5.1.8.зам, шугам сүлжээний газрын төлбөрийг нэг метр тутамд 45 төгрөгөөр;

5.1.9.улсын тусгай хэрэгцээний газар /улсын тусгай хамгаалалттай газраас бусад/-ын төлбөрийг зориулалтаас нь хамааран энэ хуулийн 5.1-д заасантай адилаар тооцно.

5.1.10.ойн сан бүхий газар болон усны сан бүхий газрын хамгаалалтын бүсэд холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн тухайн газар ашиглалтын зориулалтаас хамааруулан газрын 2 дахин нэмэгдүүлж тооцно.

5.1.11.улсын тусгай хамгаалалттай газар нутагт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг тухайн газар ашиглалтын зориулалтаас хамааруулан 3 дахин нэмэгдүүлж тооцно. Энэ заалтад улсын бүртгэлтэй асрамжийн газар, хүүхдийн зуслан болон төрийн өмчийн ерөнхий боловсролын байгууллага, хүүхдийн ясли, цэцэрлэг хамаарахгүй.

5.1.12.мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр өөрийн газар болон орчны газрынхаа газрын төлөв байдал, чанарын үзүүлэлтийг доройтуулсан, ногоон байгууламжийн эзлэх хувийг бууруулсан нь тогтоогдвол газрын нэгдмэл сангийн ангиллаас хамааруулан газрын төлбөрийг 3 дахин нэмэгдүүлж тооцно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ГАЗРЫН ТӨЛБӨР НОГДУУЛАХ, ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ

6 дугаар зүйл. Газрын төлбөр ногдуулах

6.1.Энэ хуулийн 3.1.1-д заасан газрын төлбөр төлөгчид газрын төлбөрийг аймаг, нийслэл, дүүргийн газрын албаны газрын төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн, сумын газрын даамал ногдуулна.

6.2.Газрын төлбөрийг эрх бүхий этгээдийн шийдвэрт заасны дагуу олгосон газрынх нь нийт хэмжээнд ногдуулна.

6.3.Газрын төлбөрийг газрын эрхийг улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно.

6.4.Эрхийн улсын бүртгэлд газрын эрхийг шинээр бүртгүүлсэн бол газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ тухайн жилд ногдох газрын төлбөрийн хэмжээг хувь тэнцүүлэн ногдуулж 10 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

6.5.Газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ газрын суурь үнэ, газрын үнийн бүс, газрын зориулалт, төлбөрийн хувь, хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр уг өөрчлөлттэй холбогдуулан газрын төлбөрийг шинэчлэн ногдуулж өөрчлөх тухай шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор татварын албанд хүргүүлнэ.

6.6.Газрын асуудал эрхэлсэн байгууллага /албан тушаалтан/ энэ хуулийн 6.1-д заасан газрын жилийн төлбөрийг тухайн оны 02 дугаар сарын 10-ны дотор татварын албанд хүргүүлнэ.

6.7.Бэлчээрийн газрын төлбөрийг "малчин өрх", "мал бүхий иргэн, хуулийн этгээд"-тэй гэрээ байгуулан нийт хонин толгойд шилжүүлсэн малын тоонд ногдуулна.

6.8.Газрын төлбөр ногдуулах аргачлал, зааврыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

7 дугаар зүйл. Газрын төлбөрөөс хөнгөлөх, чөлөөлөх

7.1.Газрын төлбөр төлөгчийг дараах хувь, хэмжээгээр газрын төлбөрөөс хөнгөлнө:

7.1.1.мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр өөрийн эзэмшлийн газар болон орчны газрынхаа төлөв байдал, чанарын үзүүлэлт, ногоон байгууламжийн эзлэх хувийг нэмэгдүүлсэн нь тогтоогдвол 70 хувиар;

7.1.2.атаршсан талбайд жимс, жимсгэнэ тариалсан иргэн, хуулийн этгээдийг газрын төлбөрөөс эхний жилд 100 хувиар, хоёр дахь жилд 80 хувиар, гурав дахь жилд 50 хувиар;

7.1.3.байгалийн гамшигаас цөлжсөн, хагас цөлжсөн, элэгдэл эвдрэлд орсон, химийн бодисоор бохирдсон, хордсон газрыг өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээж, ойжуулан ашиглаж байгаа газрын эрхтэй иргэн, хуулийн этгээдийг газрын төлбөрөөс эхний 3 жилд 100 хувиар;

7.1.4.жимс, жимсгэнэ, мод үржүүлгийн зориулалтаар ашиглуулсан газрыг анхны ургац өгөх хүртлэх хугацаагаар газрын төлбөрөөс 100 хувиар;

7.1.5.чөлөөт бүсэд худалдаа, аялал жуулчлал, зочид буудлын үйлчилгээ эрхэлж байгаа хуулийн этгээдийг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс газрын төлбөрөөс эхний таван жилд 100 хувь, дараагийн гурван жилд 50 хувиар;

7.1.6.чөлөөт бүсэд эрчим хүч, дулааны эх үүсвэр, шугам сүлжээ, цэвэр усан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, авто зам, төмөр зам, нисэх онгоцны буудал, харилцаа холбооны үндсэн сүлжээ зэрэг дэд бүтэц болон үйлдвэрлэл эрхэлж байгаа хуулийн этгээд, түүний салбарыг үйл ажиллагаагаа эхэлсэн өдрөөс газрын төлбөрөөс эхний 10 жилд 100 хувиар;

7.1.7.гамшиг, аюулт үзэгдэл, цар тахлын нөхцөл байдлыг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор хязгаарлалтын дэглэм тогтоосон нутаг дэвсгэрт хамрагдаж байгаа газрын хязгаарлагдмал эрх эзэмшигчийн газрын төлбөрийг нөхцөл байдал арилах хүртэл хугацаагаар 90 хувиар.

7.3.энэ хуулийн 7.1.7-д заасан газрын төлбөрөөс хөнгөлөх шийдвэрийг газар ашиглалтын зориулалтаас хамааруулан Засгийн газар гаргана.

7.2.Газрын төлбөр төлөгчийг дараах газрын төлбөрөөс чөлөөлнө:

7.2.1.“малчин өрх”-ийг хадлангийн газрын төлбөрөөс;

7.2.2.улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг хангах зориулалт бүхий газар болон шинжлэх ухаан технологийн сорилт, туршилт байгаль орчин, цаг агаарын төлөв байдлын байнгын ажиглалтын талбайн газрыг;

7.2.3.сууц өмчлөгчдийн холбоонд гэрээгээр ашиглуулж байгаа орчны газрыг;

7.2.4.төрийн байгууллагын нийтийн эдэлбэрийн зориулалтаар ашиглаж буй газрыг;

7.2.5.төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, асрамжийн газар, хүүхдийн зуслан, сургалтын төвийн газрыг;

7.2.5.Засгийн газраас жагсаалтаар тогтоосон түүх, соёлын дурсгалт барилга, байгууламжийн доорх газрыг.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ГАЗРЫН ТӨЛБӨРИЙГ ТӨВЛӨРҮҮЛЭХ, ТАЙЛАГНАХ, ХЯНАЛТ ТАВИХ

8 дугаар зүйл. Газрын төлбөрийг төвлөрүүлэх

8.1.Татварын алба нь газрын төлбөрийн ногдуулалтын талаарх мэдээллийг газрын төлбөр төлөгчид цахим, бусад хэлбэрээр мэдэгдэнэ.

8.2.Газрын нэгж талбарын дугаар, газар ашиглалтын төрөл, газрын суурь үнийн бүс, талбайн хэмжээ, газрын суурь үнэ, төлбөр төлөгч, төлбөрийн хувь хэмжээ, ногдуулалт, төлөлттэй холбоотой бусад мэдээллийг цахим, бусад хэлбэрээр харилцан солилцох журмыг газрын болон татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дарга хамтран батална.

8.3.Газрын төлбөр төлөгч тухайн жилийн төлбөрийг тэнцүү хэмжээгээр хуваан улиралд ногдох төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор төлөх бөгөөд дараа улирлуудын төлбөрийг урьдчилан төлж болно.

8.4.Газрын төлбөрийн орлогыг Төсвийн тухай хуулийн дагуу аймаг, нийслэл, сум, дүүргийн төсөвт оруулна.

9 дүгээр зүйл. Газрын төлбөрийг төлөвлөх, тайлагнах

9.1.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дараа оны төсөвт төвлөрүүлэх газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний төслийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэн жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

9.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 9.1-д заасан газрын төлбөрийн орлогын төлөвлөгөөний төслийг нэгтгэн 6 дугаар сарын 1-ний дотор газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь энэ хуулийн 9.2-т заасан төслийг хянан үзэж 6 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

9.4.Газрын төлбөрийн орлогын тайланг Татварын ерөнхий хуулийн дагуу тайлагнана.

10 дугаар зүйл. Газрын төлбөрт хяналт тавих

10.1. Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Татварын ерөнхий хуулийн дагуу газрын төлбөрийн ногдуулалт, төлөлтөд хяналт тавина.

ТАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

11 дүгээр зүйл. Газрын төлбөрийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

11.1. Газрын төлбөрийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Газрын тухай хууль, Татварын ерөнхий хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11.2. Газрын төлбөрийг 2 жил дараалан төлөөгүй тохиолдолд гэрээг цуцалж газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийг албадан буулгах, газар чөлөөлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлнэ.

12 дугаар зүйл. Газрын төлбөр, татвартай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх

12.1. Газрын төлбөртэй холбогдон үүссэн дараах маргааныг дор дурдсан байгууллага, албан тушаалтан хянан шийдвэрлэнэ:

12.1.1. төлбөр төлөгч болон газрын асуудал эрхэлсэн албаны холбогдох албан тушаалтны хооронд үүссэн маргааныг тухайн албан тушаалтны дээд шатны байгууллага, албан тушаалтан;

12.1.2. төлбөр төлөгч болон Засаг даргын хооронд үүссэн маргааныг тухайн Засаг даргын дээд шатны байгууллага, албан тушаалтан;

12.1.3. төлбөр төлөгч болон татварын албаны холбогдох албан тушаалтны хооронд үүссэн маргааныг Татварын ерөнхий хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт заасан этгээд;

12.2. Төлбөр төлөгч газрын төлбөртэй холбогдсон маргааны талаар энэ зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл уг маргааныг шүүх шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1. Энэ хуулийг 202.. оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ